

The image shows a modern building with a glass facade. The logo for 'Mongolian Re' is prominently displayed. 'Mongolian' is written in white on a dark blue background, and 'Re' is written in white on a red square. Below this, the Mongolian text 'ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ' is visible in white.

Mongolian Re
ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ

ЖИЛИЙН ТАЙЛАН 2022

УЛААНБААТАР ХОТ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт бизнесийн түншүүд Та бүхэндээ удирдлагын багийн нэрийн өмнөөс болон хувиасаа энэ өдрийн мэнд хүргэе!

Манай байгууллага байгуулагдсан цагаасаа хойш улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ тасралтгүй оруулсаар найм дахь жилдээ амжилт бүтээлээр дүүрэн ажиллалаа. Бид өсөн нэмэгдэж буй зах зээлийн шаардлагад нийцүүлэн давхар даатгалын үйлчилгээг үзүүлж,

харилцагч байгууллагуудынхаа итгэлт түнш байх урт хугацааны зорилго тавин ажиллаж байна.

Өнгөрсөн хоёр жил хагасын хугацаанд дэлхий нийтийг хамарсан цар тахал болон геополитик, улс төрийн төвөгтэй нөхцөл байдал, худалдааны хориг арга хэмжээнүүд нь эрчим хүч, хүнс болон түүхий эдийн зах зээлд цохилт өгч, улмаар дэлхийн улс орнуудад инфляцын түвшинг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг сааруулах,

улмаар хэрэглээний барааны үнэ өсөх, ажилгүйдлийн түвшин нэмэгдэх, эдийн засгийн өсөлт удаашрах гэх мэт олон сөрөг нөлөөллийг улс орнуудад бий болгосноор бизнесийн орчин хүнд сорилтуудтай нүүр туллаа.

Энэхүү хүндрэл бэрхшээлийг даван туулж, Монгол Улсын даатгалын салбар тайлант хугацаанд нийт 304.8 тэрбум төгрөгийн хураамж төвлөрүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 23.1%-иар өссөн үзүүлэлттэй байна. Үндэсний давхар даатгал ХК-ийн хувьд 4.1 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлж нийт хөрөнгө 60.3 тэрбум төгрөг болон өргөжиж, 2018 оноос хойш 6.3 тэрбум төгрөгийг улсын төсөвт татвар болон ногдол ашиг хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Бид үйл ажиллагааны орлогоор үндсэн хөрөнгөө 5 жилийн дотор 2 дахин өсгөж, ашгаасаа улсын төсөвт хуваарилдаг, томоохон татвар төлөгч байгууллага болжээ.

Өнгөрөгч 2022 онд Үндэсний давхар даатгал ХК нь олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээ үзүүлэх, үйлчлүүлэгчдийнхээ хөрөнгө, санхүүгийн эрсдэлгүй найдвартай байдлыг хангах, албан хаагчдын чадамжийг үнэлж тасралтгүй дээшлүүлэх компанийн үйл ажиллагааны чанарыг сайжруулах зорилгоор олон улсын чанарын менежментийн ISO9001 стандартыг нэвтрүүлэх бэлтгэх ажлыг бүрэн хангаж дуусгалаа. Мөн салбарын оролцогч байгууллагуудтайгаа нягт хамтран ажиллаж, дотоодын зах зээлийн эрэлт хэрэгцээнд, тулгуурласан давхар даатгалын үйлчилгээ үзүүлэх чиглэлийг барин ажиллалаа.

2023 онд Үндэсний давхар даатгал ХК нь дараах 3 үндсэн зорилтод төвлөрч ажиллахаар болно. Нэгдүгээрт, Улсын Их Хурлаас зарим төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан арилжаалж олон нийтэд нээлттэй компани болгохоор шийдвэрлэсний дагуу манай компани хувьцаагаа Монголын Хөрөнгийн Бирж дээр

нээлттэй арилжихаар бэлтгэл ажлуудыг бүрэн хангаад байна. Компани олон нийтийн нээлттэй хувьцаат компани болсноор компанийн засаглал сайжрах, санхүүгийн сахилга бат, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэл даах чадвар нэмэгдэн даатгалын салбарыг тэлэх ач холбогдолтой юм.

Хоёрдугаарт бид Үндэсний давхар даатгагчийн хувьд олон улсын зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх санхүүгийн чадавх болон зээлжих зэрэглэлийн олон улсын үнэлгээ авахаар ажиллаж байгаа бөгөөд 2025 онд Төв Азийн давхар даатгалын зах зээлд өөрийн оролцоогоо ханган ажиллахаар зорьж байна.

Гуравдугаарт, андеррайтингийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, санхүүгийн салбарт эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх замаар компанийн болон хувьцаа эзэмшигчийн хөрөнгийг нэмэгдүүлэх тодорхой зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг төр, хувийн хэвшлийн түншлэлд гол үүрэг гүйцэтгэдэг байр сууриа бэхжүүлж, даатгалын салбарын оролцогч байгууллагуудтай нягт хамтран ажиллаж байна.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхэд хамтрагч байгууллагууд, түншүүд та бүхний итгэлцэлд суурилсан хамтын ажиллагаа үнэтэй дэмжлэг болох юм. Үндэсний давхар даатгал ХК-ийн нийт удирдлагын нэрийн өмнөөс болон хувиасаа хувьцаа эзэмшигчид, төлөөлөн удирдах зөвлөл, эрхэм үйлчлүүлэгчид, даатгалын салбарын журмын нөхөд болон хамт олондоо чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Та бүхэндээ сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

Хүндэтгэсэн, Гүйцэтгэх захирлын үүргийг

түр орлон гүйцэтгэгч,

Б. Жавхланта

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Чойжилсүрэнгийн
ТАВИНЖИЛ

Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга



Зоригтбаатар
ЭНХБОЛД

Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга



Пүрэвжав
ЭРДЭНЭБААТАР

Монголын даатгалын холбооны Удирдах зөвлөлийн дарга, “Монре даатгал” ХХК-ийн Гүйцэтгэх захирал



Цэндгомбо
БОЛОРЧУЛУУН

ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга



Даржаа
НАСАНЖАРГАЛ

“Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо”-ны Удирдах зөвлөлийн гишүүн



Аюуш
ДЭМБЭРЭЛ

ҮСХ-ны Даргын зөвлөх



Цогоо
ДАШДОНДОГ

Хараат бус гишүүн



Сүхрагчаа
МӨНХТӨР

Хараат бус гишүүн



Янжив
БАТХАНД

Хараат бус гишүүн

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хууль болон бусад хууль, журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хүрээнд компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлуудаар хуралдаж шийдвэр гаргаж ажилладаг.

Үндэсний давхар даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хууль болон Үндэсний давхар даатгал ХК-ийн дүрэмд заасны дагуу 9 гишүүнтэй ба 3 гишүүн нь хараат бус гишүүн. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21.1-д “Давхар даатгалын компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд санхүүгийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, даатгуулагч болон даатгагчийн төлөөллийг оруулна”, Компанийн тухай хуулийн 75.4-д “Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна” гэж заасны дагуу дээрх байгууллагуудаас төлөөллийг оруулан ажилладаг.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Төлөөлөн удирдах зөвлөлийн хороод нь “Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын ажиллах журам”-д заасан тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд тухайн асуудлаар санал, зөвлөмж, үнэлэлт, дүгнэлт гаргаж Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, хуульд заасан зарим асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй.

ЭРСДЭЛИЙН ХОРОО

Хорооны дарга – Я.Батханд
 Гишүүд – А.Дэмбэрэл,
 П.Эрдэнэбаатар,
 Д.Насанжаргал

АУДИТЫН ХОРОО

Хорооны дарга – Ц.Дашдондог
 Гишүүд – С.Мөнхтөр,
 Ц.Болорчулуун

ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРОО

Хорооны дарга – С.Мөнхтөр
 гишүүд
 Гишүүд – Ц.Дашдондог,
 А.Дэмбэрэл

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

Хорооны дарга – З.Энхболд
 Гишүүд – Ц.Дашдондог,
 С.Мөнхтөр

Хороод нь дээрх бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаандаа хамтын шийдвэр гаргах, ил тод, шуурхай, хариуцлагатай байх зарчмыг баримтлан байнгын ажиллагаатай ажиллаж байна.

КОМПАНИЙН БҮТЭЦ



ТАНИЛЦУУЛГА

Mongolian Re

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ

Үндэсний давхар даатгал ХК нь Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, валютын гадагшлах урсгалыг бууруулах, олон улсын стандартад нийцсэн давхар даатгалын тогтолцоог хөгжүүлэх зорилгоор 2014 онд байгуулагдсан төрийн өмчит хувьцаат компани юм.

Бид олон улсын стандартад нийцсэн давхар даатгалын үйлчилгээг үзүүлэн ажиллахын зэрэгцээ А.М Бэст агентлагийн “А” үнэлгээтэй дэлхийн шилдэг давхар даатгалын компаниудтай хамтран ажиллаж харилцагчдынхаа эрсдэлгүй байдлыг ханган ажиллаж байна.



АЛСЫН ХАРАА

Бид Монгол Улсын даатгалын зах зээлийг олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээгээр хангаж, даатгалын салбарын эдийн засгийн хөгжилд үзүүлэх үр нөлөөг дэмжинэ.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид үйлчлүүлэгчдийнхээ хөрөнгө, санхүүгийн эрсдэлгүй найдвартай байдлыг ханган давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, даатгалын салбарын өсөлт хөгжлийг дэмжинэ.



ҮНЭТ ЗҮЙЛС

- МЭРГЭШСЭН ӨНДӨР ЧАДАВХ** – Даатгалын мэргэжлийн өндөр үр чадвартай боловсон хүчин.
- МАНЛАЙЛАЛ** – Цаашдын зорилго зорилтыг тодорхойлон бусдад үлгэрлэх, чиглүүлэх нэгтгэх, хамтдаа бодит үйл хэрэг болгоно.
- ХАМТЫН ЗҮТГЭЛ** – Бусадтай хүндэтгэлтэй хандаж, итгэлцэл бий болгон хамт олонтойгоо үр дүнтэй хамтран ажиллаж бүтээмжийг нэмэгдүүлнэ.
- ҮНЭНЧ ШУДАРГА ЗАРЧИМ** – Монгол Улсын хууль журмыг чандлан мөрдөж, компанийн ёс зүйн дүрмийг өдөр тутамд мөрдлөг болгон ажиллана.

ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС

2014
ОН

Компани үүсгэн
байгуулагдав.

2016
ОН

Улаан буудайн
индексжүүлсэн
даатгалыг
туршилтын
байдлаар
нэвтрүүлэв.

2017
ОН

Олон улсад
экспортын зээл,
хөрөнгө
оруулалтын
даатгалын салбарт
тэргүүлэгч Бернийн
холбооны гишүүн
байгууллагаар
элсэв.

2021
ОН

Азийн батлан даалт,
зээлийн даатгалын
холбоо /Asian
guarantee, credit
insurance association/-
той хамтын ажиллагаа
тогтоож, гишүүн
байгууллагаар элсэв.

2020
ОН

Улаан буудайн
индексжүүлсэн
даатгалыг орчин
үеийн дэвшилтэт
технологи дээр
үндэслэн
боловсруулж,
орон даяар
амжилттай
нэвтрүүлэв.

2018
ОН


Гэнэтийн осол, хөрөнгө,
эрчимжүүлсэн мал аж ахуй,
ачаа тээвэр, хариуцлага,
санхүүгийн даатгалд давхар
даатгалын үйлчилгээ
үзүүлсэн ба нэмэлтээр
агаарын хөлгийн их бие,
барилга угсралт, авто
тээврийн хэрэгслийн
даатгалын хэлбэрүүдээр
давхар даатгалын үйлчилгээ
үзүүлэв.

2022 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

01 Даатгагчийн баталгааны шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж эхэллээ. Манай улсын хувьд иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд аливаа тендэрт оролцохдоо банканд бэлэн мөнгө байршуулах, эсвэл зээл авах хэлбэрээр банкны баталгаа гаргуулдаг байсан нь банкны баталгаанд хөрөнгөө түгжих, санхүүгийн боломжгүй бол тендэрт оролцох ч боломжгүй болох зэрэг хүндрэлийг учруулдаг байсан. Уг асуудлыг шийдвэрлэх зорилгоор Даатгалын тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт 2022 оны 12 дугаар сард батлагдлаа. Үндэсний давхар даатгал ХК-ийн зүгээс Монголын

даатгалын холбоо болон даатгалын компаниудтай хамтран судалгаа хийж иргэд, хувийн хэвшилд үүсээд буй уг санхүүгийн ачаалал, зардлыг бууруулах зорилго бүхий санхүүгийн бүтээгдэхүүн боловсруулан ажиллаж байна. Мөн эдгээр хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу иргэдийн орон сууцны ипотекийн урьдчилгаа төлбөрийг даатгалаар, даатгалын баталгаагаар шийдвэрлэх боломж бүрдэж байгаа бөгөөд банк болон даатгалын салбарын хамтын ажиллагааг тэлэх, иргэдэд ирэх санхүүгийн үйлчилгээний зардал илүү хямд болох гэх мэт давуу талтай болох юм.

02 Сөүлийн баталгааны даатгалын компани Seoul Guarantee Insurance Company-тай хамтын ажиллагааг хөгжүүлэн ажиллав. Тухайлбал даатгалын зах зээлийг тэлэх, цаашилбал улс орны эдийн засгийн хөгжилд томоохон түлхэц өгөх даатгагчийн баталгааг Монгол Улсад бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх зорилгоор Санхүүгийн Зохицуулах Хороо болон БНСУ-ын “Сөүлийн баталгааны даатгал” компанитай хамтран “Баталгааны даатгал, эдийн засаг дахь үүрэг оролцоо, хэрэгжүүлэх арга хэлбэр” сургалт, уулзалтыг 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгууллаа.



03

Даатгалын компанийн гол эрсдэлүүдэд хөрөнгө оруулалтын эрсдэл байдаг. 2022 онд тус эрсдэлийг бууруулах, хөрөнгө оруулалтын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор Компанийн хөрөнгө зохицуулах журмыг ТУЗ-өөр шинэчлэн батлуулсан.

04

Компанийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор ISO9001:2015 чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд холбогдох судалгаа шижилгээг хийж гүйцэтгэн, холбогдох дүрэм, журмуудыг шинэчлэн баталсан бөгөөд өдөр тутмын үйл ажиллагаандаа ISO9001:2015 стандартыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Одоогоор тус стандартын баталгаажуулалтын аудит хийгдэх ажил явагдаж байна.

05

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс” шинэчлэн батлагдсантай холбогдуулан компанийн засаглалын холбогдох дүрэм, журмуудыг батлан ажиллалаа.

06

Дотоодын ердийн даатгалын компаниудын 90 гаруй хувьд нь давхар даатгалын үйлчилгээ үзүүлэн, хамтран ажиллав.


07

Дотоодын давхар даатгалын зуучлагч компаниудтай хамтран ажиллаж байна.


Mongolian Re

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ


САНХҮҮГИЙН ҮР ДҮН




НИЙТ ХӨРӨНГӨ /ТЭРБҮМ ТӨГРӨГ/



НИЙТ ОРЛОГО БА ЦЭВЭР АШИГ /ТЭРБҮМ ТӨГРӨГ/



ДААТГАЛЫН ХУРААМЖ /ТЭРБҮМ ТӨГРӨГ/



НӨӨЦ САН /ТЭРБҮМ ТӨГРӨГ/



ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ



ФАКУЛЬТАТИВ

- Хөрөнгө
- Гэнэтийн осол, эмчилгээний даатгал
- Ачаа тээвэр
- Гүйцэтгэгчийн болон барилга угсралт
- Хариуцлага
- Малын индексжүүлсэн даатгал
- Эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгал
- Газар тариалангийн даатгал



ТРИТИ

- Хөрөнгө
- Санхүүгийн даатгал/бизнес тасалдал
- Гэнэтийн осол
- Ачаа тээвэр
- Гүйцэтгэгчийн болон барилга угсралтын даатгал
- Хариуцлагын даатгал
- Хүнд даацын тээврийн хэрэгсэл, тусгай зориулалтын машин механизм



ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ

- Бүтээгдэхүүний хариуцлага
- Ажил олгогчийн хариуцлага
- Мэргэжлийн хариуцлага
- Удирдах ажилтнуудын хариуцлага



АЧАА ТЭЭВЭР

- Усан болон агаарын тээвэр
- Дотоодын дамжин өнгөрөх тээвэр
- Борлуулагч, худалдан авагчийн сонирхол



САНХҮҮГИЙН ДААТГАЛ

- Санхүүгийн даатгал
- Зээлийн даатгал
- Даатгалын баталгаа



АГААРЫН ХӨЛӨГ

- Агаарын хөлгийн бүх эрсдэлийн даатгал
- Агаарын хөлгийг эзэмших, өмчлөх, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал



ИНЖЕНЕРЧЛЭЛ, БАРИЛГА УГСРАЛТ

- Гүйцэтгэгчийн болон барилга угсралтын даатгал



ХӨРӨНГӨ

- Бүх төрлийн хөрөнгө
- Авто тээврийн даатгал

РЕТРО ТРИТИ ГЭРЭЭНИЙ ЧАДАВХ



РЕТРО ТРИТИ ГЭРЭЭНИЙ ЧАДАВХ

10

ХӨРӨНГӨ
 /Бизнес
 тасалдал орсон/-
 10 сая ам.доллар

10

CAR/EAR
 -10 сая
 ам.доллар

05

АЧАА ТЭЭВЭР
 -5 сая ам.доллар

05

ХАРИУЦЛАГА
 -5 сая ам.доллар

1


**ГЭНЭТИЙН
 ОСОЛ**
 -1 сая ам.доллар

2

Тусгай зориулалтын
 машин механизм болон
 хүнд даацын тээврийн
 хэрэгсэл-2 сая ам.доллар




ХУРААМЖИЙН ХАРЬЦАА




мянган төгрөг	2020 он	2021 он	2022 он
● МАЛ АМЬТДЫН ДААТГАЛ, МИД	1,513.30	1,520.30	1,296.40
● ХӨРӨНГӨ	709	1,116.00	1,315.1
● ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ	22.7	815.3	906.1
● АГААРЫН ХӨЛГИЙН ДААТГАЛ	190.8	185.1	127.2
● ХАРИУЦЛАГА	529.5	205.8	165.4
● БУСАД	606.9	310.8	270.4

НӨХӨН ТӨЛБӨР НИЙТ ₮184.5 СЯА



АНДЕРРАЙТИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛ




▲
Даатгуулсан малын тоо толгой 2022

Малын индексжүүлсэн даатгалаар 2022 онд Ард Даатгал ХК, Бодь Даатгал ХК, МИГ Даатгал ХХК, Монгол Даатгал ХК, Монре Даатгал ХХК, Мөнх даатгал ХХК, Практикал Даатгал ХХК, Хаан Даатгал ХХК, Тэнгэр даатгал ХХК болон ХААН банк, Төрийн банктай хамтран ажиллаж, нийт малчин өрхийн 11.06 хувийг даатгалд хамрууллаа. Нийт 3 тэрбум 911 сая төгрөгийн хураамж төвлөрүүлж, 125 малчин өрхөд 5 сая 835 мянган төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна.

Улсын хэмжээгээр 2022 оны эцэст, мал тооллогын дүнгээр 71.1 сая толгой мал тоологдож, өмнөх оноос 3.8 сая (5.6%)-аар өслөө. Энэ жилийн МИД-ын борлуулалтад ямаа, хонин сүргийг хамгийн их даатгуулсан байна.

М ИД хэрэгжсэн 17 жилийн хугацаанд давхардсан тоогоор 293,403 малчин өрхийн 61.8 сая толгой малыг даатгалд хамруулж, 30 тэрбум 906 сая төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлжээ. Эдгээрээс 45,974 малчин өрх нийт 8 тэрбум 339 сая төгрөгийн нөхөн төлбөр авч, энэхүү даатгалын ач тусыг малчид амьдрал дээр бодитоор хүртээд байна.





ХАМТРАН АЖИЛЛАСАН ДОТООДЫН ДААТГАЛЫН КОМПАНИУД



ХАМТРАН АЖИЛЛАСАН ГАДААД ТҮНШҮҮД



中国太平
CHINA TAIPING

tinubu®

SCOR
The Art & Science of Risk



Swiss Re



ODYSSEYRE®



UlysseRe

hannover re®



PANA HARRISON

PINC

INSURANCE



VINARE



GIC Re



AGCIA
Asia Guarantee & Credit
Insurance Association



TYSERS



RC



MANDARIN RE



WORLD BANK GROUP



GENESIS
Insurance Brokers &
Benefits Consultants Ltd

Your Best Credit Partner
SGI Seoul Guarantee
Insurance

new/re

PeakRe >



J. B. BODA
75 years & beyond.
WE BELIEVE

75

optima
INSURANCE EXPERTS

Your Best Credit Partner
SGI Seoul Guarantee
Insurance

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

Үндэсний давхар даатгал ХК нь Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, олон улсын стандартад нийцсэн давхар даатгалын тогтолцоог хөгжүүлэх зорилгын хүрээнд олон улсын төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэн Монгол Улсад шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж ирсэн.

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ДААТГАЛ:



Монгол Улсын гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөлт, гамшгийн эрсдэлийн тухай хууль эрх зүй, бодлого, институцийн тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор Азийн Хөгжлийн Банк (АХБ)-аас “Монгол Улсын гамшгийн эрсдэлийг үнэлэх, бууруулах, шилжүүлэх хэрэгслийг чадавхжуулах” техник туслалцааны (ТТ) төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд Монгол

Улсын Сангийн сайдын 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 60 дугаар тушаалаар “Гамшгийн эрсдэлийн даатгалын эрх зүйн орчныг бүрдүүлэх, холбогдох санал, зөвлөмжийг боловсруулах” үүрэг бүхий хамтарсан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа болно. Гамшгийн эрсдэлийн даатгалын тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд түүнтэй холбоотой бүтээгдэхүүн боловсруулах, учирч болзошгүй хохирол, эрсдэлийн үнэлгээ хийх, гамшгийн эрсдэлийн санхүүжилтийн талаар ойлголтыг нэмэгдүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, эрсдэлийг шилжүүлэхэд олон улсын сайн туршлагыг судлах зэрэг ажлуудыг ажлын хэсэгтэй хамтран гүйцэтгэсэн болно.

**ЭКСПОРТЫН
ЗЭЭЛИЙН
ДААТГАЛ:** 

Уул уурхайн бус салбарын

жигжиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх болон экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Хөгжлийн Ассоциацитай хамтран хэрэгжүүлж буй Экспортыг дэмжих төслийн хүрээнд Үндэсний давхар даатгал ХК нь экспортын зээлийн даатгалыг Монгол Улсад нэвтрүүлээд байна.

Энэхүү даатгалын зорилго нь бизнесийн байгууллага хоорондын худалдааг хөнгөвчлөх, харилцан ашигтай бизнес хийх боломжийг бүрдүүлж, эрсдэлийг бууруулах явдал юм. Уг даатгалын эрсдэлийн ихэнх хэсгийг олон улсын тэргүүлэх давхар даатгагч СКОР хариуцах ба гадаад худалдан авагчдын зээлийн шинжилгээг олон улсын тэргүүлэх ТИНҮБҮ компани гүйцэтгэнэ. Экспорт эрхлэгчдийн хэрэгцээ, олон улсын стандартад нийцсэн экспортын зээлийн даатгалын үйлчилгээгээр дамжуулан Үндэсний давхар

даатгал ХК, Бодь даатгал ХК болон Миг даатгал ХХК танд дараах шийдлийг санал болгож байна.

- Худалдан авагчдын санхүүгийн чадавхын талаарх мэдээлэл, үнэлгээг олон улсын тэргүүлэх байгууллагатай хамтран чанартай, түргэн шуурхай хийж үйлчилнэ.
- Худалдан авагчид төлбөрөө төлөөгүй тохиолдолд даатгалаас таны авлагыг нөхөн төлнө.
- Зээлийн менежментийг нэвтрүүлэхэд тань дэмжлэг үзүүлнэ.
- Нэмэлт санхүүжилт авах

боломжийг бүрдүүлнэ.

- Авлага барагдуулах үйлчилгээг үзүүлнэ.

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА



Бид БНХАУ-ын Хуатай иншуранс аженси болон консалтинг сервис /Huatai Insurance Agency; Consulting Service LDT/ олон улсын давхар даатгалын зуучлагчтай хамтран ажиллахаар болсон. Хуатай иншуранс аженси болон консалтинг сервис компани нь 1993 онд байгуулагдсан, Хятадын Давхар даатгалын Корпорацийн 52.5 хувийн хөрөнгө оруулалттай компани юм.

Азийн батлан даалт, зээлийн даатгалын холбоо /Asian guarantee, credit insurance association/-ноос 2022 онд Ази тивийн зээлийн даатгалтай холбоотой

салбарт үйл ажиллагаа амжилттай эрхэлж буй санхүүгийн байгууллагуудын гишүүн байгууллагуудын жилийн уулзалтад оролцож, санал солилцон, хамтарч ажиллалаа. Тус холбооны төлөөллүүд 2022 оны 9 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд Монгол Улсад айлчилж БНСУ-ын баталгаа, зээлийн даатгалын бизнес, туршлагын талаарх мэдээллийг хуваалцлаа. Уулзалтын үр дүнд тус холбооноос Үндэсний давхар даатгал ХК-тай хамтын ажиллагаа, гадаад харилцааг хөгжүүлэх зорилгоор Сөүлийн баталгааны даатгалын компанитай хамтын ажиллагаа эхлүүлж, туршлага солилцов. АОН Ре /AON Re/ давхар даатгалын компанийн Төв Азийг хариуцсан салбарын төлөөлөгчидтэй 2022 оны 5 дугаар сард уулзаж, цаашид компанийн хариуцлагаас давсан эрсдэлийг шилжүүлэх, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх зэрэгт хамтран ажиллах талаар тохиролцлоо.



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлийг илрүүлэх, шинжлэх, оновчтой удирдах арга аргачлалыг боловсруулж, компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог шинэчлэн, эрсдэлийг илэрхийлэх индикаторууд, даатгалын онцлог харьцаа үзүүлэлтүүд, үйл ажиллагааны хяналт болон тайлагналын тогтолцоог тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна. Үндсэн гол үзүүлэлтүүдээс авч үзвэл даатгалын андеррайтингийн үйл ажиллагааг үнэлдэг хосолсон харьцаа болон төлбөрийн чадварын зохистой харьцаа юм.

ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2021 ОН	2022 ОН
Төлбөрийн чадварын зохистой харьцаа (Шалгуур >=200%)	341%	314%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа (Шалгуур >=110%)	229%	236%

ДАВХАР ДААТГАГЧИЙН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ҮҮДЭХ ЭРСДЭЛИЙН АНГИЛАЛ

- ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ
 - СТРАТЕГИЙН ЭРСДЭЛ
 - САНХҮҮГИЙН ЭРСДЭЛ
 - КОМПЛАЕНС ЭРСДЭЛ

ЭРСДЭЛИЙН ЗАСАГЛАЛ

Компанийн эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь бизнесийн стратеги зорилтуудад хүрэх явцад учирч болзошгүй саад тогтор, эсхүл илүү боломж буюу ердийн үйл ажиллагааг савлуулахад хүргэдэг хэвийн бус нөлөөллийг хэмжиж, түүнд тохирсон арга хэмжээг хэрэгжүүлэх замаар эрсдэл өгөөжийн оновчтой түвшинг хадгалах явдал юм. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд компанийн удирдлага, ажилтнууд оролцдог.

Эрсдэлийн төрөл ангилал Эрсдэлийг компанийн үндсэн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалттай уялдуулан дараах төрлүүдэд ангилан тодорхойлсон.

ДАВХАР ДААТГАГЧИЙН ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛИЙН ЭРСДЭЛИЙН АНГИЛАЛ

- Оролцогч талуудын эрсдэл
- Улс төрийн эрсдэл
- Хууль эрх зүйн орчны эрсдэл
- Нийгмийн эрсдэл
- Макро эдийн засгийн эрсдэл
- Санхүү, хөрөнгө оруулалтын эрсдэл

Эрсдэлийг бүтэн дүр зургаар харж тодорхойлох, урьдчилан сэргийлэх, удирдах нь компанийн эрсдэлийн бодлогын гол зорилго юм. Тиймээс дээрх эрсдэлүүдээс гадна шинээр бий болж буй болон гэнэтийн эрсдэлүүдийг тодорхойлж, удирдах нь эрсдэлийн удирдлагын чухал хэсэг байдаг.

ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Үндэсний давхар даатгал ХК нь 2022 онд Андеррайтингийн газар, Бизнес хөгжил, төслийн газар, Комплаенс, нөхөн төлбөрийн газар, Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газар, Захиргаа, удирдлагын газар гэсэн 5 газар нэгжтэй, 42 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явууллаа. Манай компанийн нийт ажиллагсдын 70 орчим хувь нь 20-40 насны залуус байдаг бөгөөд нийт ажилтнуудын 75.5 хувь нь даатгалын салбарт дунджаар 5-аас дээш жил ажилласан туршлагатай ажилтнууд байна. Мөн нийт ажилтнуудын 85 гаруй хувь нь даатгал, банк санхүү, эдийн засаг, хууль эрх зүй, бизнесийн удирдлага, маркетинг болон менежментийн мэргэжилтэй ажилтнууд бөгөөд 60 орчим хувь нь магистрын зэрэг хамгаалсан байна.



БОЛОВСОН
ХҮЧИН

42



МАГИСТРЫН
ЗЭРЭГ
ХАМГААЛСАН

60%

20-40 НАСНЫ
ЗАЛУУЧУУД

70%



ДААТГАЛЫН
САЛБАРТ 5-С
ДЭЭШ ЖИЛ
АЖИЛЛАСАН

75.5%

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

БАЙГАЛЬ ОРЧИН



Үндэсний давхар даатгал ХК-ийн ажилчид жил бүрийн 5, 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногт зохиогддог “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-т 2018 оноос хойш оролцсон. Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд улиас, агч, монос, бүйлс зэрэг нийт 100 гаруй мод тарьжээ.



НИЙГЭМ



Нийгмийн хариуцлагын хүрээнд манай хамт олон амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой айлуудын болон өвлийн гутал хувцас муутай байгаа бяцхан хүүхдүүдэд өвлийн хувцас халуун сэтгэлээр дулаацуулах зорилготой 2013 оноос хойш орон даяар амжилттай хэрэгжиж буй “Дулаан гутал” аяныг дэмжиж нэгдлээ. Ажилтнуудын цуглуулсан дулаан хувцас болон сайн дураар хуримтлуулсан мөнгөөрөө гутал хувцас авч хүлээлгэн өглөө.



БОЛОВСРОЛ



Үндэсний давхар даатгал ХК Монголын даатгалын холбоо, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран даатгалын төлөөлөгчийн эрх олгох сургалт, шалгалтыг Хөвсгөл, Булган, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Увс, Говь-Алтай, Дорнод, Сүхбаатар аймгуудад 2022 оны 3-р сарын 09-ний өдрөөс 3-р сарын 26-ны өдрийн хооронд зохион байгуулав. Уг сургалтыг Монголын даатгалын холбооны сургагч багш нар болон Үндэсний давхар даатгал ХК-ийн андеррайтерууд хамтран удирдаж явуулсан ба аймаг бүрт 2 өдрийн танхимын сургалт оров. Нийт 352 төлөөлөгч сургалтад хамрагдаж, 308 төлөөлөгч эрх олгох шалгалт өгснөөс 247 төлөөлөгч буюу 80.2 хувь нь тэнцэж, даатгалын төлөөлөгчийн эрх авах шаардлага хангасан байна.

АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

Бид “Үндэсний Давхар Даатгал” ХК (цаашид “компани” гэх)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мянган гүйлгээний тайланг (цаашид “хураангуй санхүүгийн тайлан” гэх) 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аудитын тайлангаас хураангуй авч бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр, энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартаар шаардсан бүх тодруулгыг иж бүрэн агуулаагүй тул “Үндэсний давхар даатгал” ХК -ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй.



АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН БА ТҮҮНД ӨГСӨН БИДНИЙ ДҮГНЭЛТ

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд эерэг дүгнэлт өгсөн.

УДИРДЛАГА БОЛОН ЗАСАГЛАХ ЭРХ МЭДЭЛ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮДИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

АУДИТОРЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Бидний үүрэг хариуцлага бол аудитын олон улсын стандарт, Монгол улсын аудитын тухай хуулийн дагуу хийсэн аудитдаа үндэслэн энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.

САҢХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ҮЛДЭГДЭЛ	2021 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ҮЛДЭГДЭЛ
------------------	--	--

ХӨРӨНГӨ

ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ



Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,311,522	592,542
Даатгалын авлага болон бусад авлага	449,669	631,025
Урьдчилж төлсөн зардал	365,770	12,694
Бараа материал	5,833	5,789
Давхар даатгалын хойшлогдсон хураамж	475,393	345,003
Хөрөнгө оруулалт	56,896,723	55,444,887
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	59,504,910	57,031,940

ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгө	243,326	308,898
Биет бус хөрөнгө	325,923	422,133
Ашиглах эрхтэй хөрөнгө	222,622	11,166
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	4
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	791,871	742,201

НИЙТ ХӨРӨНГӨ	60,296,781	57,774,141
---------------------	-------------------	-------------------

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр

2022 ОНЫ 12 САРЫН
31-НИЙ ҮЛДЭГДЭЛ2021 ОНЫ 12 САРЫН
31-НИЙ ҮЛДЭГДЭЛ

ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ

Өр төлбөр



Санхүүгийн өр төлбөр	406,402	98,665
Санхүүгийн бус өр төлбөр	886 2,142	
Хойшлогдсон татварын өр	20,015	16,896
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	1,703,312	1,740,147
Хамтын эрсдэлийн сан	1,907,423	1,764,888
Эрсдэлээс хамгаалах сан	9,169,707	4,975,605
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	13,207,725	8,598,343
ЭЗДИЙН ӨМЧ		
Эзэмшигчдийн өмч	24,500,000	24,500,000
Эздийн өмчийн бусад хэсэг	489,264	489,264
Алдагдлаас хамгаалах сан	19,000,000	19,000,000
Хуримтлагдсан ашиг	3,099,792	5,186,534
Эздийн өмчийн дүн	47,089,056	49,175,798
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	60,296,781	57,774,141

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

мянган төгрөгөөр	2022 ОН	2021 ОН
Даатгалын хураамжийн орлого	4,084,232	4,153,339
Даатгалын хураамжийн буцаалт	(76,986)	(74,478)
Давхар даатгалын хураамжийн зардал	(1,598,286)	(1,767,432)
ДАВХАР ДААТГАЛЫН ЦЭВЭР ОРЛОГО	2,408,960	2,311,429
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	36,835	(545,007)
Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт	130,390	(149,637)
ОРЛОГОД ТООЦСОН ХУРААМЖ	2,576,185	1,616,785
Нийт нөхөн төлбөрийн зардал	(185,507)	(1,046,661)
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	-	420,674
Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	(809,551)	(521,974)
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	365,770	12,694
НӨХӨН ТӨЛБӨРИЙН ЦЭВЭР ЗАРДАЛ	(944,795)	(1,138,167)
Хөрөнгө оруулалтын орлого	4,956,652	5,353,090
Бусад даатгалын хураамжийн бус орлого	85,595	125
Ерөнхий ба удирдлагын зардал	(2,932,081)	(2,609,564)
Санхүүгийн зардал	(30,431)	(15,043)
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	(299,079)	(500,681)
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)	3,412,046	2,706,545
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ	2,913,258	2,160,490



Mongolian Re






ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ

 7577 0002

 info@mongolianre.com

 <http://mongolianre.com/>



-  <https://facebook.com/MongolianRe>
-  <https://instagram.com/mongolianreinsurance>
-  <https://youtube.com/@mongolianre6433>
-  <https://linkedin.com/company/mongolian-re/>
-  https://twitter.com/Mongolian_Re